

**“ӨНДӨР ХААН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2019 оны 3 сарын 19 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

“ӨНДӨР ХААН” ХК –ийн 2019 оны 3 сарын 19 –ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2 дугаар тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. “ӨНДӨР ХААН” ХК –ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 сарын 29 –ний өдөр 13:00 цагт, Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, Жигжиджавын гудамж, 5/3 тоот Стандарт Финанш Групп Оффисын II давхарын хурлын танхимд хуралдуулсугай. Хурлыг ТУЗ –ийн дарга Г.Хатанболд даргалсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 4 сарын 10 –ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл” –ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2019 оны 3 сарын 21 –ний өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” –ын дагуу 2019 оны 3 сарын 22 –ны өдөр болон 2019 оны 4 сарын 5 –ны өдрүүдэд олон нийтэд зарласугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2019 оны 3 сарын 27 –ны өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтуудын жагсаалт, уг бичиг баримтуудтай танилцаж болох газар, хугацааг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Долоо. Хурлын өдөр ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахаас гадна брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2019 оны 4 сарын 26 –ны өдрөөр тогтоож, санал авах хуудасны агуулга, загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Найм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг 5 дугаар хавсралтаар баталсугай.

**“ӨНДӨР ХААН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2019 оны 3 сарын 19 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг даалгасугуй.

Зохион байгуулах комиссын дарга: Х.Баатархүү

Гишүүн: Л.Гангуяа

Арав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилж, даалгах ажлыг 6 дугаар хавсралтаар баталсугай.

Тооллогын комиссын дарга: Н.Төгөлдөр

Гишүүд: Б.Дэжидмаа

С.Сувд-Эрдэнэ

ТУЗ –ийн ДАРГА:

Г.ХАТАНБОЛД

ТУЗ –ийн ГИШҮҮД:

Ц.ГАНБОЛД

Н.УЛААНХҮҮ

Г.ОДОНГУЯА

Д.БАТТУЛГА

Д.БАЯРСАЙХАН

Ө.ХАНГАЛ

М.НЯМСҮРЭН

Г.ДАВАА-ОЧИР



Нямсүрэн